



ЗАВХАН АЙМАГ  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 1/01

Улиастай

Ээлжийн амралтын хуваарь батлах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1, Оюуны Өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын хөдөлмөрийн дотоод журмын 7.23 дугаар заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хэлтсийн албан хаагчдын ээлжийн амралтыг нэгдүгээр, Сумдын улсын бүртгэгч нарын ээлжийн амралтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Албан хаагчдын ээлжийн амралтын олговрыг ээлжийн амралт олгох, тухай "мэдэгдэл"-ийг үндэслэн тооцож олгохыг Ахлах нягтлан бодогч /Б.Мөнхсүлд/-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Улсын бүртгэгч /Н.Энхбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж. СҮХБААТАР



ЗАВХАН АЙМАГ  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 01 сарын 10 өдөр

Дугаар

А/02

Улиастай

Ур чадварын нэмэгдэл олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 50.1, Засгийн газрын 1995 оны 6 дугаар сарын 14-ны өдрийн 96 дугаар тогтоол, Улсын бүртгэлийн ерөнхий газрын орон нутаг дахь бүртгэлийн байгууллагын дүрмийн 3.3.10, "Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын хөдөлмөрийн дотоод журам"-ын 7.31 дүгээр заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Тус хэлтсийн 2016 оны хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ амжилттай биелүүлэн ажилласан албан хаагчдад ур чадварын нэмэгдлийг хавсралтад дурдсан хэмжээгээр олгосугай.

2.Албан хаагчдад олгох ур чадварын нэмэгдлийг Хэлтсийн төсвийн холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б. Мөнхсүлд/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.СҮХБААТАР



ЗАВХАН АЙМАГ  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 01 сарын 19 өдөр

Дугаар 1/03

Улиастай

Комисс томилох тухай

Оюуны Өмч, Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2017 оны Б/16, Б/17 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Хэлтсийн иргэний бүртгэлийн Улсын бүртгэгч Баранзайбазарын Цогзолмаа, албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Эрдэнээгийн Эрхжаргалан нарын ажлыг хүлээлцэх комиссыг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга: И.Батсайхан – Улсын ахлах бүртгэгч

Гишүүд: Н.Энхбат - Улсын бүртгэгч

С.Мөнгөнцэцэг - Мэдээлэл технологийн ажилтан

2. Ажлыг холбогдох хууль, журмын дагуу хүлээлцэж, ажил хүлээлцсэн тэмдэглэлийг 2017 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Хэлтсийн даргад танилцуулахыг комиссын дарга /И.Батсайхан/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.СҮХБААТАР

0 00006



ЗАВХАН АЙМАГ  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/04

Улиастай

Комисс томилох тухай

Оюуны Өмч, Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн Б/123 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Ургамал сумын Улсын бүртгэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Цэвэгмидийн Батгэрэлийн ажлыг хүлээлцэх комиссыг доорх бүрэлдэхүүнтэй ажиллуулсугай. Үүнд:

Комиссын дарга: Н.Энхбат – Улсын бүртгэгч

Гишүүд: Б.Мөнхсүлд – Ахлах нягтлан бодогч

Д.Жаргалсайхан – Улсын бүртгэгч

2. Ажлыг холбогдох хууль, журмын дагуу хүлээлцэж, ажил хүлээлцсэн тэмдэглэлийг 2017 оны 03 дугаар сарын 10-ны өдөр хэлтсийн даргад танилцуулахыг комиссын дарга /Н.Энхбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.СҮХБААТАР

000003



ЗАВХАН АЙМАГ  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/05

Улиастай

Комисс томилох тухай

Оюуны Өмч, Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн Б/131, Б/132 дугаар тушаалуудыг үндэслэн ТУШААХ нь:

1.Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга бөгөөд Улсын ахлах бүртгэгч Нямсүрэнгийн Наранбилэг, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн Улсын бүртгэгч Махмэдрийн Ариунжаргал нарын ажлыг хүлээлцэх комиссыг доорх бүрэлдэхүүнтэй ажиллуулсугай. Үүнд:

Комиссын дарга: Б.Бат-Эрдэнэ – Хяналтын Улсын байцаагч

Гишүүд: И.Батсайхан – Улсын ахлах бүртгэгч

Б.Мөнхсүлд- Ахлах нягтлан бодогч

С.Мөнгөнцэцэг – Мэдээлэл технологийн ажилтан

2.Ажлыг холбогдох хууль, журмын дагуу хүлээлцэж, ажил хүлээлцсэн тэмдэглэлийг 2017 оны 03 дугаар сарын 10-ны өдөр хэлтсийн даргад танилцуулахыг комиссын дарга /Б.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.СҮХБААТАР

000010

my doc: tushaal



ЗАВХАН АЙМАГ  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1/06

Улиастай

Илүү цагийн хөлс олгох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1, "Оюун өмч, Улсын бүртгэлийн Ерөнхий газрын хөдөлмөрийн дотоод журам"-ын 7 дугаар зүйлийн 7.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 1988 оноос 2014 он хүртлэх иргэний бүртгэлийн төрөлт, гэрлэлт, нас баралтын бүртгэлийг Улсын бүртгэлийн цахим сантай тулган, зөрчлийг арилгах ажилд илүү цагаар ажилласан Хэлтсийн зарим ажилтан албан хаагчдад илүү цагийн хөлсийг тооцон олгосугай.

2. Илүү цагийн хөлсөнд зарцуулах 621172 /Зургаан зуун хорин нэгэн мянга нэг зуун далан хоёр/ төгрөгийг Хэлтсийн холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Мөнхсүлд/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.СҮХБААТАР

My document A-4

0000012



ЗАВХАН АЙМАГ  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 1/07

Улиастай

Хөрөнгө актлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь заалт, 31 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолын 2.1 дэх заалт, 2017 оны А-5/952 тоот "Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах тухай" албан бичиг, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2017 оны 1/3707 тоот "Хөрөнгө актлах тухай" албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хэлтсийн дансанд бүртгэлтэй ашиглалтын шаардлага хангахгүй, болсон хавралтад дурдсан 5 нэр төрлийн 10 ширхэг 9,231,257.34 /Есөн сая хоёр зуун гучин нэгэн мянга хоёр зуун тавин долоон төгрөг 34 мөнгө/ төгрөгний анхны өртөгтэй хөрөнгийг акталсугай.

2. Дээрх хөрөнгүүдийг акталж устгах ажлыг зохион байгуулж тайланг 2017 оны 05 сарын 17 –ны өдрийн дотор танилцуулахыг "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-д даалгасугай.

3. Акталж, устгагдаж байгаа үндсэн хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хөрөнгийн хөдлөлийг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасны дагуу бүртгэлд тусгахыг Ахлах нягтлан бодогч /Б.Мөнхсүлд/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.СҮХБААТАР

010018



ЗАВХАН АЙМАГ  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/109

Улиастай

Тооллогын комисс томилох тухай

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4.5.4 дүгээр заалтуудыг тус тус үндэслэн **ТУШААХ НЬ:**

1.Хэлтсийн эд хөрөнгийн 2017 оны эхний хагас жилийн тооллого явуулах комиссыг доорхи бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга: С.Норов -Улсын бүртгэгч

Гишүүд: М.Шүрэнцэцэг- Архивч  
М.Ариунжаргал- Улсын бүртгэгч

2.Комиссын дарга / С.Норовт /-т даалгах нь

2.1. Тооллогыг 2017 оны 06-р сарын 20-ноос 22-ны хооронд хийх

2.2. Тооллогыг холбогдох хууль, заавар журмын дагуу явуулах

2.3.Тооллогын дүн болон Хэлтсийн актлах шаардалгатай хөрөнгийн жагсаалтыг гаргаж байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлд танилцуулах.

ХЭЛТСИЙН ДАРГА  Ж.СҮХБААТАР



My doc: A4

000026





ЗАВХАН АЙМАГ  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/109

Улиастай

Илүү цагийн хөлс олгох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1, "Оюун өмч, Улсын бүртгэлийн Ерөнхий газрын хөдөлмөрийн дотоод журам"-ын 7 дугаар зүйлийн 7.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр илүү цагаар ажилласан Хэлтсийн мэдээлэл технологи, шуурхай багийн албан хаагчдад илүү цагийн хөлсийг тооцон олгосугай.

2. Илүү цагийн хөлсөнд зарцуулах 2045890 /Хоёр сая дөчин таван мянга найман зуун ерэн/ төгрөгийг Хэлтсийн холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Мөнхсүлд/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.СҮХБААТАР

My document A-4

000023



ЗАВХАН АЙМАГ  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/10

Улиастай

Мэргэшлийн зэргийн нэмэгдэл  
олгох тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1, Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн.

ТУШААХ нь:

1. Хэлтсийн жолооч А.Амгаланбаатар-д мэргэшсэн жолоочийн нэмэгдэл олгосугай.
2. Жолооч А.Амгаланбаатар-д мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 15,0 хувиар бодож сар бүр олгохыг ахлах нягтлан бодогч /Б.Мөнхсүлд/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.СҮХБААТАР



ЗАВХАН АЙМАГ  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 11 сарын 30 өдөр

Дугаар А/11

Улиастай

Комисс томилох тухай

1. Тосонцэнгэл сумын гэрээт ажилтан Б.Нансалмаагийн ажил хүлээлцэх комиссыг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга: Б.Батбаатар – Тосонцэнгэл сумын Улсын бүртгэгч

Гишүүд: П.Батбаатар- Тосонцэнгэл сумын Эд хөрөнгийн Улсын бүртгэгч

2. Ажлыг холбогдох хууль, журмын дагуу хүлээлцэж, ажил хүлээлцсэн тэмдэглэлийг 2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр хэлтсийн даргад танилцуулахыг комиссын дарга Тосонцэнгэл сумын Улсын бүртгэгч / Б.Батбаатар /-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.СҮХБААТАР

my doc: tushaal

000024